

Projektträger:  Экологийн Боловсролын Төв  
МОНГОЛ УАСЫН ИХ СУРГУУЛЬ



Mit freundlicher Unterstützung:



Centrum für internationale  
Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft  
aus gtz und 

BMZ



Bundesministerium für  
wirtschaftliche Zusammenarbeit  
und Entwicklung



## Erlebnis - Umwelt

Ein Bildungsprojekt für die Zukunft

### “Байгаль орчны танин мэдэхүйн хүлэмж” төсөл

Экологийн боловсролын төв (ЭБТ) ХБНГУ-ын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ) болон Германы Олон улсын шилжилт хөдөлгөөн, хөгжлийн төв (CIM)-ийн дэмжлэгээр, ХБНГУ дахь Монголын академичдын холбоо (МАХ, VMA)-той хамтран “Байгаль орчны сургалт, танин мэдэхүйн хүлэмж” төслийг 2014 оны 3 сараас 2015 оны 2 сар хүртэл нэг жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлж дуусгав. ЭБТ-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх, сургалтын шинэ хөтөлбөрүүдтэй болгох зорилго бүхий уг төслийн нийт төсөв хоёр зуун сая төгрөг бөгөөд Германы Олон улсын шилжилт хөдөлгөөн, хөгжлийн төв төслийн нийт санхүүжилтийн тал хувийг эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр буюу мөнгөн тусламж хэлбэрээр олгож, үлдсэн хувийг Монголын академичдын холбоо болон Экологийн боловсролын төв өөрийн ажиллах хүч, бусад нөөц бололцоогоор санхүүжүүлж ажиллалаа. Уг төслийн хүрээнд дараах үндсэн гурван үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Үүнд:

1. ЭБТ-ийн цэцгийн хүлэмжийг засварлаж, шиллэж, тохижуулах, хүлэмжинд шинээр сургалт, танин мэдэхүйн 10 өртөө байгуулах
2. ЭБТ-ийн музейн хөгжлийн концепц бичих

3. Хүүхдэд зориулсан танин мэдэхүйн цуврал нэвтрүүлгийн зохиол бичиж, олны хүртээл болгох

Уг төслийн эхний бөгөөд хамгийн чухал хэсэг болох ЭБТ-ийн цэцгийн хүлэмжийг засварлах, бүрэн шиллэж, шинээр 10 өртөө байгуулах ажил биеллээ олж, 30 гаруй жилийн өмнө баригдсан, тусгаарлалт нь муудаж, дулааны алдагдал ихэссэн хүлэмжинд ер гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, «Байгаль орчны танин мэдэхүйн хүлэмж» нэртэйгээр 2014 оны 11 сараас эхлэн үүд хаалгаа нээлээ. Уг хүлэмжийг орчин үеийн технологи бүхий поликорбанат шилээр шиллэж, засаж тохижуулснаар жилийн турш ургамал ургах таатай нөхцөл бүрдсэнээс гадна хүүхэд, олон нийтэд жилийн аль ч улиралд шинэ хөтөлбөрөөр үйлчлэх сайхан боломж нээгдэв. Уг хүлэмжинд байгуулсан Ажилсаг чийгийн улаан, Эрдэнэсийн эрэлд, Нөхөр үү, дайсан уу, Гайхамшигт хувирал зэрэг 10 хөтөлбөр нь танин мэдэхүйн бодит, сонирхолтой орчин болж, хүүхэд залуусын ирэх дуртай газрын нэг болов. Уг төслийн үр дүнд ЭБТ байгаль-экологийн музейгээ хөгжүүлэх концепцтой болж, хүүхдэд зориулсан байгаль орчин, танин мэдэхүйн 20 цуврал бичигдлээ.

Хүлэмжийн төсөл хэрэгжихийн өмнөх ба дараах байдал







### Хүлэмжинд байгуулсан танин мэдэхүйн өртөө


“Хуурай газрын хатад” өртөө



“Агаарын үйлдвэр” өртөө



“Хөрс” өртөө



“Гайхамшигт хувирал” өртөө



## Байгаль орчин, танин мэдэхүйн хүлэмжийн анхны зочид



Уг төсөл ЭБТ-ийн ахлах мэргэжилтэн Др.Р.Сүнжидмаа болон МАХ-ны УЗ-ийн дарга Др.Д.Гүнцэцэг нарын удирдлаган дор үлгэр жишээ, амжилттай хэрэгжсэнд төсөл хэрэгжүүлэгч талууд сэтгэл хангалуун байгаа бөгөөд хойшид олон нийтийн, тэр дундаа Монголын хүүхэд, залуусын байгаль орчны боловсролд өөрийн бодит хувь нэмрийг оруулах их ажлын эхлэл болсон гэж найдаж байна.

Монголын хойч үе болсон хүүхэд, залуусын оюунд хөрөнгө оруулалт хийх таатай орчныг бүрдүүлж өгсөн Германы Олон улсын шилжилт хөдөлгөөн, хөгжлийн төв болон ХБНГУ дахь Монголын академичдын холбооны хамт олонд баярласан талархсанаа илэрхийлж байна.

Экологийн боловсролын төв

2015 оны 2 сар